

ТАНИЛЦУУЛГА

Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Монгол Улсын Ерөнхийлөгч 2021 оны 10 дугаар сарын 4-ний өдөр “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 59 дүгээр зарлиг гарган ойн салбарын бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулахыг Засгийн газарт чиглэл болгосны дагуу Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

Ойн тухай хууль 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр шинэчилсэн найруулгаар батлагдсанаас хойш 9 жилийн хугацаанд 7 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ.

Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулагдаж байгаа “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулах, төрийн захиргааны байгууллагын ажил үүрэг оновчтой, уялдаатай байх, иргэн, хуулийн этгээдийн ойн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, төрийн байгууллагаас олгох эрх, зөвшөөрлийн тоог бууруулах шинэчлэл хийх зорилгоор боловсруулсан. Хуулийн төсөлд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг яамны эрхлэх нийтлэг асуудалд нийцүүлэх, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, ойн талаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангах ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх зүйн үндсийг тогтоох, ойн үр, үрийн нөөцийн сан бий болгох зэрэг зохицуулалтыг тусгасан.

Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь дараах ач холбогдолтой гэж үзэж байна:

-Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байгуулагдсанаар ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих ажил сайжирна. Монгол орны ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ нэмэгдэж, 2030 он гэхэд нийт газар нутгийн 9 хувьд хүргэх ногоон хөгжлийн зорилго хангагдана. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ нэмэгдсэнээр нүүрсхүчлийн хийн шингээлт нэмэгдэж, цөлжилтийг сааруулах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад үзүүлэх эерэг нөлөө үлэмж их юм.

-Ойн үрийн аж ахуйг судалгаа шинжилгээнд тулгуурлан, бодлого чиглэлтэй хөгжүүлснээр шилмэл сортын ойн үрийн сан бүрдүүлэх, улмаар ойжуулах, ойг нөхөн сэргээх ажилд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлнэ;

-Төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгодог тогтолцоог өөрчилж магадлан итгэмжлэлд хамрагдан зохих шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллага нь ойн аж ахуйн үйл ажиллагааг эрхэлж болох зохицуулалт хийсэн. Энэ нь иргэн, хуулийн этгээдэд учрах хүндрэл бэрхшээлийг арилгаж, төрийн албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг бууруулж, төрд итгэх олон нийтийн

итгэл нэмэгдэнэ. Түүнчлэн хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу улсын хилийн шугам дайран гарсан ойд улсын хилийн зурвас гаргах, сэргээхтэй холбоотой үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тусгасан;

2007 онд батлагдсан Ойн тухай хуулийн дагуу ойн асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага болох Ойн газар нь Засгийн газрын агентлагийн статустай байгуулагдан, 2012 оны 8 дугаар сарыг хүртэл үйл ажиллагаагаа явуулжээ. Монгол Улс нь НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц, Цөлжилттэй тэмцэх конвенц, Биологийн төрөл зүйлийн конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх, “Алсын хараа-2050” хөгжлийн бодлогод тусгасан зорилтод хүрэхийн тулд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг хуульчлах шаардлагатай.

Иймд ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулийн төсөлд тусгасан. Мөн төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан бүсийн ойн аж ахуйг хөгжүүлэх зохицуулалтыг орууллаа.

Модлог ургамлын үр, үржлийн материалын асуудлыг хуульд тусгайлан заасан бөгөөд ойн үрийн гарал үүсэл, чанар, үрийн улсын нөөцийн сан, үрийн удмын сангийн хадгаламж байгуулах, судалгаа туршилтын лаборатори ажиллуулах эрх хэмжээг ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцийн дагуу ойн магадлан итгэмжлэлийг нэвтрүүлэн магадлан итгэмжлэлд хамрагдсан хуулийн этгээд нь ойн мэргэжлийн байгууллага болж, дүгнэлтэд үндэслэн гэрчилгээг нь ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгоно. Ойн магадлан итгэмжлэлд тавигдах шаардлага, журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлан мөрдүүлнэ.

Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгэж, ойн салбарын ажилтан, албан хаагчдаас судалгаа авсан болно. 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс 15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Ойн салбарын үндэсний чуулган”-аас гаргасан зөвлөмжийн зарим асуудлыг хуулийн мөн төсөлд тусгасан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР